



ДУНДГОВЬ АЙМАГ
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 4/21

Мандалговь

Хүнсний аюулгүй байдлыг хангах ажлыг
эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3"а" дахь заалт, Хүнсний аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.3 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 27 дугаар зүйл, 29 дугаар зүйлийн 29.3.1 дэх заалт, Ерөнхий боловсролын сургуулийн Үдийн цай үндэсний хөтөлбөрийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нар нь үдийн цай, хоолонд хэрэглэгдэж байгаа мах, сүү сүүн бүтээгдэхүүнийг аймгийн мал эмнэлгийн лабораторийн ариун цэврийн магадлан шинжилгээнд сард 3-аас доошгүй удаа хамруулан шинжилгээний бичгээр баталгаажуулсугай.

2. Эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангаагүй, шинжилгээний дүгнэлтгүй, гарал үүсэл нь тодорхойгүй ил задгай газар худалдаалагдаж байгаа мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг худалдаж авахгүй байхыг сургууль цэцэрлэгийн удирдлагад үүрэг болгосугай..

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг сургууль, цэцэрлэгийн удирдлагуудад, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга, улсын байцаагч (Е.Отгонцэцэг)-т, Хүнс, үйлдвэр, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн (Б.Саранзаяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Р.МӨНХТОГТОХ

